



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/358

Ховд

Булган сумаас гарах мал, амьтны  
шилжилт хөдөлгөөнийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Булган сумын Алаг толгой багийн нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний халдварыг таслан зогсоох, голомтыг устгах, халдвар дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Булган сумаас гарах мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зогсоож, амьд мал тээвэрлэх, тууварлах, отор нүүдэл хийх, бүх төрлийн баяр наадам, үзэсгэлэн, хурдан морины уралдаанд оролцох зэрэг үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хориглосугай.

2. Шүлхий өвчний үед мөрдөж байгаа хорио цээрийн дэглэмийг чангатгаж, тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнд хатуу хяналт тавьж, Булган сумаас гарах, орох гол зам, цэгүүдэд шалган нэвтрүүлэх пост байгуулж, байнгын ажиллагаанд оруулж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Ж.Дамдинбазар), Цагдаагийн газар (Э.Даваасүрэн), Онцгой байдлын газар (Б.Алтанбадралт) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Булган сумын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийхийг хориглох шийдвэр гаргаж мөрдүүлэх, малчид иргэдэд сэрэмжлүүлэг, мэдэгдэл хүргэх, хил залгаа орших Үенч сумын Улиаст, Жаргалан багуудын нутаг, отор нүүдэл, тээврийн хэрэгслийн гол зам, цэгүүдэд харуул пост гаргаж, хяналт тавьж ажиллахыг Үенч сумын Засаг дарга (Э.Уртнасан), Алтай сумын Засаг дарга (Х.Түмэндэлгэр), Мөнххайрхан сумын


Засаг дарга (Б.Батболд), Дуут сумын Засаг дарга (С.Ганзориг) нарт үүрэг болгосугай.

4. Булган сум болон зүүн, төвийн бүсийн аймгуудаас амьд мал хүлээн авахаас татгалзах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд хатуу хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Батцэнгэл), нийт сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, дархлаажуулах, халдварыг таслан зогсоох, голомтыг устгах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Батцэнгэл), Булган сумын Засаг дарга (Ж. Дамдинбазар) нарт үүрэг болгосугай.

6. Захирамжын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ